

“САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЯНАХ, ҮНЭЛЭХ, БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ”

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Журмын зорилго, хамрах хүрээ

1.1 Төрийн аудитын байгууллага Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5, 8.7-д заасны дагуу шалгагдагч этгээдийн санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргийг гүйцэтгэсэн аудитын хуулийн этгээд (цаашид “гүйцэтгэгч” гэх)-ийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2 Энэхүү журам нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3 Энэхүү журам нь “Санхүүгийн тайланд аудит хийсэн аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх заавар, аргачлал” бүхий хавсралт, маягтаас бүрдэнэ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

АУДИТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЯНАХ

Хоёр. Аудитын ажлын гүйцэтгэлийг хянах

- 2.1 Үндэсний аудитын газар болон Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар гүйцэтгэгчийн хийсэн аудитын ажлын гүйцэтгэлийн хяналтыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын чанарын хяналтын журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 2.2 Шалгагдагч этгээдийн санхүүгийн тайланд аудит хийсэн гүйцэтгэгчийн аудитор болон түүнээс дээш албан тушаалтан аудитын үе шатны ажлын гүйцэтгэлээ хянуулна.
- 2.3 Чанарын хяналтыг Төрийн аудитын байгууллагын аудитор, ахлах аудитор, аудитын менежер, тэргүүлэх аудитор гүйцэтгэнэ.
- 2.4 Гүйцэтгэгч нь аудитын ажлын гүйцэтгэлд хяналт тавих нөхцөл, бололцоог хангасан байна.
- 2.4.1 Цахимаар хяналт тавих боломж, нөхцөлийг хангах;
- 2.4.2 Шаардлагатай тохиолдолд талбарт очиж энэхүү журмын 2.4-т заасан аудитын тухайн үе шатны ажлын чанар, горимыг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих боломж, нөхцөлийг хангах;
- 2.5 Төрийн аудитын байгууллага нь гүйцэтгэгчийн хийсэн аудитын ажлын гүйцэтгэлийн хяналтыг дараах 4 үе шатанд хэрэгжүүлнэ. Үүнд:
- 2.5.1 Аудитын төлөвлөх үе шатны хяналт;
- 2.5.2 Аудитын гүйцэтгэх үе шатны хяналт;
- 2.5.3 Аудитын тайлагнах үе шатны хяналт;
- 2.5.4 Аудитын тайлагнах дараах үе шатны хяналт;

2.6 Аудитын ажлын гүйцэтгэлийн хяналтыг аудитын ажил бүрээр хэрэгжүүлнэ.

2.7 Аудитын төлөвлөх үе шатны хяналтыг дараах асуудлуудад чиглүүлнэ.

- 2.7.1 Аудитын урьдчилсан судалгаа, дүн шинжилгээ хийсэн эсэх;
- 2.7.2 Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хэрэгжүүлэх горим сорилыг оновчтой сонгосон эсэх;
- 2.7.3 Материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандартын дагуу тогтоосон эсэх;
- 2.7.4 Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан санхүүгийн тайланд аудит хийх журмын дагуу боловсруулсан эсэх;
- 2.7.5 Төлөвлөх үе шатны ажилбарыг бүрэн гүйцэтгэсэн эсэх

2.8 Аудитын гүйцэтгэх үе шатны хяналтыг дараах асуудлуудад чиглүүлнэ.

- 2.8.1 Аудитыг гүйцэтгэхдээ аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгасан болон шинээр нэмж тодорхойлсон горим сорилыг бүрэн хэрэгжүүлсэн эсэх;
- 2.8.2 Аудитын гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолж, хянасан эсэх;
- 2.8.3 Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн асуудлын бүртгэл, төлбөрийн акт, албан шаардлагыг үйлчлүүлэгч байгууллагад танилцуулж баталгаажуулсан эсэх;
- 2.8.4 Асуудлын бүртгэлд үйлчлүүлэгчээс ирүүлсэн саналыг үнэлсэн эсэх;
- 2.8.5 Гүйцэтгэх үе шатны ажилбарыг бүрэн гүйцэтгэсэн эсэх

2.9 Тайлагнах үе шатны хяналтыг дараах асуудлуудад чиглүүлнэ.

- 2.9.1 Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газрын боловсруулж, батлуулсан аудитын тайлангийн загварын дагуу бэлтгэсэн эсэх;
- 2.9.2 Аудитаар илрүүлсэн асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрүүлсэн алдаа зөрчил, анхаарал татах асуудал, дараагийн аудитаар үзэх асуудал зэргийг аудитын тайланд бүрэн тусгасан эсэх;
- 2.9.3 Менежментийн захидалд тусгагдсан зөвлөмж нь бодлогын шинж чанартай, оновчтой, ойлгомжтой, хэрэгжихүйц, үнэлэх боломжтой эсэх;
- 2.9.4 Аудитын дүгнэлтийг аудитын олон улсын стандартын дагуу гаргасан эсэх;
- 2.9.5 Аудитын хураангуй тайлан, зөрчлийн нэгтгэл, холбогдох судалгааг баталсан загвар, маягтын дагуу үнэн зөв гаргасан эсэх;
- 2.9.6 Аудитын тайланг хэвлэлтэд бэлтгэж, цахимаар хүлээлгэж өгсөн эсэх;

2.10 Тайлагналын дараах үе шатны хяналтыг дараах асуудлуудад чиглүүлнэ.

- 2.10.1 Статистик мэдээг гаргаж нэгтгүүлсэн эсэх;
- 2.10.2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, нотлох баримтын хамт ирүүлсэн эсэх;
- 2.10.3 Гүйцэтгэгч нь аудитын ажлын баримт, нотлох зүйлсийн архвийн нэгжийг цахим хэлбэрээр ирүүлсэн эсэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АУДИТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ

Гурав. Аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх

3.1 Аудитын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрууд жил бүрийн 5 дугаар сарын 15-ны дотор хүргүүлж, Үндэсний аудитын газрын Санхүүгийн

аудитын газар 7 дугаар сарын 5-ны дотор нэгтгэнэ.

3.2 Санхүүгийн аудитын газрын нэгтгэсэн гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээний нэгтгэлд сонгон шалгаруулах ажлын хэсэг дүн шинжилгээ хийж, төрөлжсөн аудит хариуцсан орлогч гүйцэтгэгчтэй гэрээ сунгах эсэх талаарх саналаа Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.3 Гүйцэтгэсэн аудитын ажлыг дараах үзүүлэлтээр үнэлнэ.

Аудитын төлөвлөх үе шатны хяналт	30 хувь
Аудитын гүйцэтгэх үе шатны хяналт	30 хувь
Аудитын тайлагнах үе шатны хяналт	30 хувь
Аудитын тайлагналын дараах үе шатны хяналт	10 хувь

3.4 Аудитын үе шатны ажлын баримтыг аудитын программ хангамжид оруулж, дараагийн аудитад ашиглах боломжийг бүрдүүлнэ.

3.5 Гүйцэтгэгчийн хянан удирдах ажилтнууд аудитын гүйцэтгэлд, үр дүнд үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн эсэхийг үнэлгээнд хамруулна.

3.6 Гүйцэтгэгчийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ энэ журмын хавсралт "Санхүүгийн тайланд аудит хийсэн аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх заавар, аргачлал"-ыг мөрдөх бөгөөд дараах үндсэн үзүүлэлтийг харгалзана. Үүнд:

3.6.1 Аудитын төлөвлөх үе шатны ажлын гүйцэтгэлд өгөх үнэлгээ

3.6.1.1 Төлөвлөх үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг баримталсан байдал;

3.6.1.2 Журмын 2.4-т заасан ажлын гүйцэтгэлийн үнэлгээ;

3.6.2 Аудитын гүйцэтгэх үе шатны ажлын гүйцэтгэлд өгөх үнэлгээ

3.6.2.1 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн, шинж чанар, ач холбогдол;

3.6.2.2 Аудитаар илрүүлсэн зөрчлийн шийдэлд өгөх үнэлгээ;

3.6.2.3 Гүйцэтгэх үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг баримталсан байдал;

3.6.3 Аудитын тайлагнах үе шатны ажлын гүйцэтгэлд өгөх үнэлгээ

3.6.3.1 Аудитын дүгнэлтийн хэлбэрийг зөв сонгосон эсэх;

3.6.3.2 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв эсэх;

3.6.3.3 Аудитын тайлангийн тоо дүн, утга найруулга, хэлбэржүүлэлт;

3.6.3.4 Тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг баримталсан байдал;

3.6.3.5 Аудитын тайлангийн хэвлэлийн эх бэлтгэсэн байдал;

3.6.3.6 Тайлагнах үе шатны ажлын баримтыг иж бүрэн хүлээлгэн өгсөн эсэх;

3.6.4 Аудитын тайлагналын дараах үе шатны ажлын гүйцэтгэлд өгөх үнэлгээ

3.6.4.1 Статистик мэдээг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан маягтын дагуу бэлтгэж, нэгтгүүлсэн байдал;

3.6.4.2 Төлбөрийн актын барагдуулалт;

3.6.4.3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтад үндэслэн, үнэлсэн байдал;

3.6.4.4 Аудитын үе шатны ажлын баримтыг аудитын программ хангамжид иж бүрэн оруулсан байдал.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АУДИТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

Дөрөв. Аудитын ажлын чанарыг баталгаажуулах

- 4.1 Үндэсний аудитын газрын Чанарын баталгаажуулалтын асуудал хариуцсан нэгжээс аудитын хуулийн этгээдийн аудитын ажил, чанарын хяналт хэрэгжүүлсэн байдалд жил бүр чанарын баталгаажуулалт хийнэ.
- 4.2 Аудитын ажлын чанарын баталгаажуулалтад хамрагдах гүйцэтгэгч болон хийгдсэн аудитын ажлыг эрсдэлд суурилсан түүврийн аргаар сонгож Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗААЛТ

Тав. Талуудын оролцоо

- 5.1 Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан санхүүгийн тайланд аудит хийх журам, заавар, холбогдох бусад арга зүйгээр гүйцэтгэгчийг хангана.
- 5.2 Төрийн аудитын байгууллага тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад баримтлах бодлого, чиглэлийн дагуу төлөвлөгөөт сургалтуудад гүйцэтгэгчийг хамруулна.
- 5.3 Гүйцэтгэгч нь аудитыг Төрийн аудитын тухай хууль, холбогдох стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан санхүүгийн тайланд аудит хийх журам, заавар, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, холбогдох бусад журмын дагуу гүйцэтгэнэ.
- 5.4 Гүйцэтгэгч аудитын ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулахтай холбоотой баримт мэдээллийг Төрийн аудитын байгууллагаас шаардсан тухай бүрд нь гаргаж өгөх үүрэгтэй.
- 5.5 Аудитын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг гүйцэтгэгч талд танилцуулж, Үндэсний аудитын газарт Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчид, Аймаг нийслэл дэх төрийн аудитын газарт Тэргүүлэх аудитор баталгаажуулна.
- 5.6 Аудитын үе шатны ажлын гүйцэтгэлд аудитор, ахлах аудитор, аудитын менежерийн үнэлсэн үнэлгээг гүйцэтгэгч эс зөвшөөрвөл Тэргүүлэх аудиторт, Тэргүүлэх аудиторын үнэлгээг эс зөвшөөрвөл Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогчид хандаж, эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 5.7 Аудитын хуулийн этгээд гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой асуудлаар Төрийн аудитын байгууллагаас тайлбар, тодруулга авч болно.

Зургаа. Хариуцлага

- 6.1 Төрийн аудитын байгууллагаас аудитын үе шатны хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг гүйцэтгэгчид даруй мэдэгдэж, холбогдох нотлох баримт, материал, тооцоололд үндэслэн удаа дараа засвар хийлгэсэн тохиолдолд гүйцэтгэгчийн ажлын үнэлгээг бууруулна.
- 6.2 Гүйцэтгэгч нь Аудитын ажлыг чанаргүй гүйцэтгэж, хангалтгүй үнэлгээ авсан /70 хувиас доош/ тохиолдолд гэрээг сунгахгүй ба ёс зүйн зөрчил гаргасан, хараат бус байдлыг хангаж

ажиллаагүй тохиолдолд Төрийн аудитын байгууллагаас хамтран ажиллах гэрээг 3 жил хүртэл хугацаагаар байгуулах эрхийг хязгаарлана.

6.3 Гүйцэтгэгчийн аудитын ажлын гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр буруу үнэлсэн нь тогтоогдвол албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ЖУРМЫН ХАВСРАЛТЫН ТӨСӨЛ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙСЭН АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ ЗААВАР, АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1. Заавар, аргачлал боловсруулах зорилго

1.1 Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журмыг тус тус үндэслэн аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх бодлого, аргачлалыг тодорхойлоход оршино.

2. Баримтлах зарчим

2.1 Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, баталгаажуулахад ил тод, шударга, бодитой байх үндсэн зарчмаас гадна үнэлгээний дүн, дүгнэлт төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт, холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх зарчим баримтална.

3. Хамрах хүрээ

3.1 Аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн аудитын ажлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл цуглуулах, боловсруулах, гүйцэтгэлийг үнэлэх, баталгаажуулах үйл явц энэхүү заавар, аргачлалд хамаарна.

3.2 Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас аудитын хуулийн этгээдийн тухайн тайлант хугацаанд гүйцэтгэсэн санхүүгийн аудитын явц, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэлд үндэслэн ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.

Хоёр. Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлт, аргачлал

4. Үнэлгээ гаргах үндсэн үзүүлэлт

4.1 Аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг аудитын үе шат бүрээр үнэлнэ. Үүнд:

- | | |
|--|---------|
| - Аудитын төлөвлөх үе шатны хяналт | 30 хувь |
| - Аудитын гүйцэтгэх үе шатны хяналт | 30 хувь |
| - Аудитын тайлагнах үе шатны хяналт | 30 хувь |
| - Аудитын тайлагналын дараах үе шатны хяналт | 10 хувь |

4.2 Аудитын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний оноог хасах зарчмаар үнэлэх ба эцсийн үнэлгээг хувьд шилжүүлэн тооцно.

- 4.3 Аудитын ажлын гүйцэтгэлийг чанарын хяналтын эргэцийн хуудсаар бүртгэнэ.
- 4.4 Аудитын ажлын гүйцэтгэлийн анхан шатны хяналтыг аудитор, ахлах аудитор, хоёр дахь шатны хяналтыг аудитын менежер, дараагийн шатны хяналтыг Тэргүүлэх аудитор хэрэгжүүлж, үнэлнэ.
- 4.5 Гүйцэтгэлийн үе шатанд төлбөрийн акт, албан шаардлагын төсөлд хууль, эрхзүйн менежер хяналт хэрэгжүүлнэ.
- 4.6 Ерөнхий үнэлгээ нь аудитор, ахлах аудитор, аудитын менежер, Тэргүүлэх аудиторовын өгсөн үнэлгээний дундаж байна. /Маягт 1/

$$EY = AT\theta Y\text{ШY}\% + AГY\text{ШY}\% + ATaY\text{ШY}\% + ATaДY\text{ШY}\%$$

$$AT\theta Y\text{ШY} = \frac{AY\% + MY\% + TAY\%}{3} \quad AГY\text{ШY} = \frac{AY\% + MY\% + TAY\%}{3}$$

$$ATaY\text{ШY} = \frac{AY\% + MY\% + TAY\%}{3} \quad ATaДY\text{ШY} = \frac{AY\% + MY\% + TAY\%}{3}$$

Товчилсон үзүүлэлтийн тайлбар:

(EY) - Ерөнхий үнэлгээ

(AY) – Аудитор, ахлах аудиторовын үнэлгээ

(MY) – Менежерийн үнэлгээ

(TAY) – Тэргүүлэх аудиторовын үнэлгээ

(AT θ YШY) - Аудитын төлөвлөх үе шатны үнэлгээ

(AГYШY) - Аудитын гүйцэтгэх үе шатны үнэлгээ

(ATaYШY) - Аудитын тайлагнах үе шатны үнэлгээ

(ATaДYШY) - Аудитын тайлагналын дараах үе шатны үнэлгээ

- 4.7 Аудитын үе шат бүрд үнэлгээг гүйцэтгэгчид танилцуулж, баталгаажуулна.
- 4.8 Аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг гүйцэтгэгч талд танилцуулж, Үндэсний аудитын газарт төрөлжсөн аудит хариуцсан орлогч, Аймаг нийслэл дэх төрийн аудитын газарт Тэргүүлэх аудитор баталгаажуулна.
- 4.9 Аудитын үе шатны ажлын гүйцэтгэлд аудитор, ахлах аудитор, аудитын менежерийн үнэлсэн үнэлгээг гүйцэтгэгч эс зөвшөөрвөл Тэргүүлэх аудиторт, Тэргүүлэх аудиторовын үнэлгээг эс зөвшөөрвөл төрөлжсөн аудит хариуцсан орлогчид хандаж, эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 4.10 Аудитын төлөвлөх үе шатны ажлыг “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам”-ын 3.6.1-т заасны дагуу дараах байдлаар үнэлнэ. /Маягт 2/
- Аудитын урьдчилсан судалгаа хийсэн байдал 5 оноо
 - Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хэрэгжүүлэх горим сорилыг оновчтой сонгосон байдал 10 оноо
 - Материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандартын дагуу тогтоосон байдал 4 оноо
 - Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар баталсан санхүүгийн тайланд аудит хийх журмын дагуу боловсруулсан байдал 4 оноо

- Төлөвлөлтийн үе шатны ажилбарыг бүрэн гүйцэтгэсэн байдал 2 оноо
 - Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг хугацаандаа батлуулсан бол 5 оноо
- 4.11 Аудитын гүйцэтгэх үе шатны ажлыг “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам”-ын 3.6.2-т заасны дагуу дараах байдлаар үнэлнэ. /Маягт 3/
- Аудитыг гүйцэтгэхдээ аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгасан болон шинээр нэмж тодорхойлсон горим сорилыг бүрэн хэрэгжүүлсэн байдал 12 оноо
 - Аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолж, хянасан байдал 3 оноо
 - Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн асуудлын бүртгэл, төлбөрийн акт, албан шаардлагыг үйлчлүүлэгч байгууллагад танилцуулж баталгаажуулсан байдал 10 оноо
 - Асуудлын бүртгэлд үйлчлүүлэгчээс ирүүлсэн саналыг үнэлсэн байдал 3 оноо
 - Гүйцэтгэлийн үе шатны ажилбарыг бүрэн гүйцэтгэсэн байдал 2 оноо
- 4.12 Аудитын тайлагнах үе шатны ажлыг “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам”-ын 3.6.3-т заасны дагуу дараах байдлаар үнэлнэ. /Маягт 4/
- Аудитын тайлангийн төслийг загварын дагуу бэлтгэсэн байдал 6 оноо
 - Менежментийн захидалд тусгагдсан зөвлөмж нь бодлогын шинж чанартай, оновчтой, ойлгомжтой, хэрэгжихүйц, үнэлэх боломжтой байдал 5 оноо
 - Аудитын дүгнэлтийг аудитын олон улсын стандартын дагуу гаргасан байдал 4 оноо
 - Аудитын хураангуй тайлан, зөрчлийн нэгтгэл, холбогдох судалгааг баталсан загвар, маягтын дагуу үнэн зөв гаргасан байдал 6 оноо
 - Аудитын тайланг хэвлэлтэд бэлтгэж, цахимаар хүлээлгэж өгсөн байдал 4 оноо
 - Аудитын тайлан, гэрчилгээг хугацаандаа баталгаажуулсан байдал 5 оноо
- 4.13 Аудитын тайлагналын дараах үе шатны ажлыг “Санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулах журам”-ын 3.6.4-т заасны дагуу дараах байдлаар үнэлнэ. /Маягт 5/
- Статистик мэдээг гаргаж нэгтгүүлсэн байдал 3 оноо
 - Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, нотлох баримтын хамт ирүүлсэн байдал 5 оноо
 - Аудитын үе шатны ажлын баримтыг аудитын программ хангамжид иж бүрэн оруулсан байдал 1 оноо
 - Аудитын ажлын баримт, нотлох зүйлсийг цахим архив болгон ирүүлээгүй бол 1 оноо

**АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ**

(Аудитын хуулийн этгээдийн нэр)

№	Аудитын үе шатны ажлын нэр	Аудит гүйцэтгэсэн хугацаанд өгсөн үнэлгээ					
		Аудитор	Ахлах аудитор	Аудитын менежер	Газрын захирал	Хууль эрх зүйн менежер	МУЕА-ын орлогч
1	Аудитыг төлөвлөх үе шат						
2	Аудитыг гүйцэтгэх үе шат						
3	Аудитыг тайлагнах үе шат						
4	Аудитыг тайлагналын дараах үе шат						
	НИЙТ ҮНЭЛГЭЭ						

Үнэлгээ өгсөн: Аудитын менежер

_____ (овог нэр)

Хянасан: Газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

_____ Аудитын хуулийн этгээдийн нэр

_____ Албан тушаал

_____ (овог нэр)

**АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН
ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

(Аудитын хуулийн этгээдийн нэр)

№	Аудитын үе шатны ажлын нэр	Аудитын урьдчилсан судалгаа хийсэн эсэх				Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хэрэгжүүлэх горим сорилыг оновчтой сонгосон эсэх					Материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандартын дагуу тогтоосон эсэх			Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан санхүүгийн тайланд аудит хийх журмын дагуу боловсруулсан эсэх				Төлөвлөлтийн үе шатны ажилбарыг бүрэн гүйцэтгэсэн эсэх	Хугацаандаа хянуулаагүй	Дундаж үнэлгээ	
		Тухайн байгууллагын үйл ажиллагааг ойлгох ажил хийгээгүй байх	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шүүмжлэгдэж байгаа асуудлыг судлах дүн	Санхүүгийн тайлангийн үзүүлэлт болон төсөвт шийдвэрээ хийсвэрийг байх	Урьдчилсан шинжилгээг эрсдэлтэй уялдуулаагүй байх	Эрсдэлээ оновчтой тодорхойлоогүй байх	Эрсдэлийн үнэлгээг буруу хийсэн байх	Тухайн эрсдэлийг бууруулах хяналтын сорилыг тодорхойлоогүй байх	Тухайн эрсдэлд хариу өгөх горим сорил оновчтой бус байх	Залилгангийн эрсдэлийг тодорхойлоогүй байх	Суурь түвшинг буруу сонгосон байх	Суурь түвшнийг сонгосон шалтгааныг тайлбарлаагүй байх	Хувь сонгосон шалтгааныг эрсдэлтэй уялдуулаагүй буруу сонгосон байх	Суурь үзүүлэлтийн тоо дүн алдаатай	Төлөвлөгөөний загварын дагуу бэлтгээгүй байх	Үг үсэг, найруулгын алдаатай, тоо дүн зөрүүтэй байх	Төлөвлөгөөнд тодорхойлсон эрсдэл, горим сорилоо дугуу тусгасан байх				Хийх ажлуудаа хөтөлбөрт бүрэн тусгаагүй, хугацаа уялдаагүй байх
	Хасах үнэлгээ	-2	-1	-1	-1	-2	-2	-2	-2	-2	-1	-1	-1	-1	-1	-1	-1	-1	-2	-5	-30
1	Аудитор, ахлах аудитор																				30.0
3	Аудитын менежер																				30.0
3	Газрын захирал																				30.0
	НИЙТ ҮНЭЛГЭЭ																				30.0

Үнэлгээ өгсөн:

Аудитор / / (овог нэр)

Аудитын менежер / / (овог нэр)

Газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор / / (овог нэр)

Огноо:

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Аудитор / / (овог нэр) /Аудитын хуулийн этгээд/

Чанарын менежер / / (овог нэр) /Аудитын хуулийн этгээд/

Захирал / / (овог нэр) /Аудитын хуулийн этгээд/

Огноо:

**АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН
ГҮЙЦЭТГЭХ ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ**

(Аудитын хуулийн этгээдийн нэр)

№	Аудитын үе шатны ажлын нэр	Аудитыг гүйцэтгэхдээ аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу горим сорилыг бүрэн хэрэгжүүлсэн эсэх					Аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцоолж, хянасан эсэх			Аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийн асуудлын бүртгэл, төлбөрийн акт, албан шаардлагыг үйлчлүүлэгч байгууллагад танилцуулж баталгаажуулсан эсэх			Асуудлын бүртгэлд үйлчлүүлэгчээс ирүүлсэн саналыг үнэлсэн эсэх	Гүйцэтгэлийн үе шатны ажилбарыг бүрэн гүйцэтгэсэн эсэх	Хугацаандаа хянуулаагүй	Дундаж үнэлгээ	
		Төлөвлөгөө хөтөлбөрт тусгасан горим сорилыг дутуу хэрэгжүүлсэн байх	Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн /нөхцөл байдал/-г тусгаагүй байх	Аудитаар илрүүлсэн зөрчлийн шинж чанар ач холбогдолгүй байх	Алдаа зөрчил илрүүлээгүй байх	Санхүүгийн тайлангийн уялдааг шалгаагүй, дансдын тулгалтыг бүрэн хийгээгүй байх	Гүйцэтгэлийн үе шатанд суурь түвшинг үндэслэлгүй өөрчилсөн байх	Төлөвлөлийн үе шатанд сонгосон хувийг нэмэгдүүлсэн байх	Суурь үзүүлэлтийн тоо дүн алдаатай байх	Зөрчлийн шийдлийг буруу сонгосон байх	Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгч байгууллагаар баталгаажаагүй байх	Акт, албан шаардлагын үндэслэл буруу байх					Акт, албан шаардлагын үйлчлүүлэгч байгууллагаар зөвшөөрүүлээгүй байх
	Хасах үнэлгээ	-2	-1	-2	-5	-2	-1	-1	-1	-1	-1	-2	-1	-3	-2	-5	-30
1	Аудитор																30.0
2	Аудитын менежер																30.0
3	Газрын захирал																30.0
4	Хууль эрх зүйн менежер																30.0
5	МУЕрөнхий аудиторовын орлогч																30.0
	НИЙТ ҮНЭЛГЭЭ																

Үнэлгээ өгсөн:

Аудитор / (овог нэр)

Аудитын менежер / (овог нэр)

Газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор / (овог нэр)

Огноо:

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Аудитор / (овог нэр) /
/Аудитын хуулийн этгээд/

Чанарын менежер / (овог нэр) /
/Аудитын хуулийн этгээд/

Захирал / (овог нэр) /
/Аудитын хуулийн этгээд/

Огноо:

**АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН
ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ**

(Аудитын хуулийн этгээдийн нэр)

№	Аудитын үе шатны ажлын нэр	Аудитын тайлангийн төслийг загварын дагуу бэлтгэсэн эсэх		Менежментийн захидалд тусгагдсан зөвлөмж нь бодлогын шинж чанартай, оновчтой, ойлгомжтой, хэрэгжихүйц, үнэлэх боломжтой эсэх					Аудитын дүгнэлтийг аудитын олон улсын стандартын дагуу гаргасан эсэх		Аудитын хураангуй тайлан, зөрчлийн нэгтгэл, холбогдох судалгааг баталсан загвар, маягтын дагуу үнэн зөв гаргасан эсэх			Аудитын тайланг хэвлэлтэд бэлтгэж, цахимаар хүлээлгэж өгсөн эсэх		Хугацаандаа хянуулаагүй	Дундаж үнэлгээ
		Үг үсэг, найруулгын алдаатай байх	Аудитын тайлан дах тоо дүн аудитлагдсан СТ-ийн үзүүлэлтээс зөрүүтэй байх	Бодлогын шинж чанартай зөвлөмж өгөөгүй байх	Зөвлөмж оновчтой бус байх	Зөвлөмж ойлгомжгүй байх	Зөвлөмж хэрэгжих, үнэлэх боломжгүй байх	Зөвлөмж дутуу тусгасан байх	Дүгнэлтийн үндэслэл МБТ уялдаагүй байх	Хязгаарлалтын үндэслэл буруу байх	Аудитын хураангуй тайлан алдаатай, дутуу бэлтгэсэн	Аудитын хураангуй тайлангийн хавсралт зөрчлийн нэгтгэл дутуу хийсэн	Судалгааг хянаагүй, нэгтгүүлээгүй	Аудитын тайланг хэвлэлтийн эхий бэлтгэж ирүүлээгүй	Аудитын дуусгавар болгох холбогдох баримт материалыг дутуу ирүүлсэн		
	Хасах үнэлгээ	-3	-3	-1	-1	-1	-1	-1	-2	-2	-2	-2	-2	-2	-2	-5	-30
1	Ахлах аудитор																30.0
2	Аудитын менежер																30.0
3	Газрын захирал																30.0
	НИЙТ ҮНЭЛГЭЭ																30.0

Үнэлгээ өгсөн:

Аудитор	/	/
		(овог нэр)
Аудитын менежер	/	/
		(овог нэр)
Газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор	/	/
		(овог нэр)
Огноо		

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Аудитор	/	/
		(овог нэр)
Чанарын менежер	/	/
		(овог нэр)
Захирал	/	/
		(овог нэр)
Огноо		

АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН ДАРААХ ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

(Аудитын хуулийн этгээдийн нэр)

№	Аудитын үе шатны ажлын нэр	Статистик мэдээг гаргаж нэгтгүүлсэн эсэх		Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, нотлох баримтын хамт ирүүлсэн эсэх			Аудитын үе шатны ажлын баримтыг аудитын програм хангамжид иж бүрэн оруулсан эсэх	Аудитын ажлын баримт, нотлох зүйлсийг цахим архив ирүүлээгүй байх
		Статистик мэдээг ирүүлээгүй	Статистик мэдээг буруу гаргасан	Төлбөрийн актын барагдуулалт	Албан шаардлын биелэлт нотлох баримтгүй	Зөвлөмжийн хэрэгжилт нотлох баримтгүй		
		-2	-1	-1	-2	-2	-1	-1
1	Аудитор							
2	Аудитын менежер							
	НИЙТ ҮНЭЛГЭЭ							

Үнэлгээ өгсөн:

Аудитор	/	/
		(овог нэр)
Аудитын менежер	/	/
		(овог нэр)
Газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор	/	/
		(овог нэр)
Огноо:		

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Аудитор	/	/
/Аудитын хуулийн этгээд/		(овог нэр)
Чанарын менежер	/	/
/Аудитын хуулийн этгээд/		(овог нэр)
Захирал	/	/
/Аудитын хуулийн этгээд		(овог нэр)
Огноо:		

